

**БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГЫГ СОНГОХ ТУХАЙ  
АСУУДЛЫГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ ХҮНИЙ ХӨГЖИЛ,  
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 07 дугаар  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг Та бүхэнд танилцуулж байна.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурал дахь XYH намын зөвлөлөөс нэр дэвшигчийн төрийн ажлын мэдлэг, ур чадварыг харгалзан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Бадрах овогтой Найдалааг нэр дэвшүүлж, хэлэлцүүллээ.

Б.Найдалаа нь 1975 онд төрсөн, эхнэр 3 хүүхдийн хамт амьдардаг, 1993 онд Нийслэлийн 23 дугаар сургуульд бүрэн дунд боловсрол эзэмшиж, 1997 онд Санхүү эдийн засгийн дээд сургуулийг бизнесийн удирдлагын бакалавр, 2004 онд Япон улсын Кобе их сургуулийг эдийн засгийн ухааны магистр, хөгжлийн эдийн засагч мэргэжлээр төгссөн. 1997-2002 онд Санхүү эдийн засгийн дээд сургуульд эдийн засгийн онолын багш, 2004-2008 онд Анод болон Хаан банкны Эрсдэлийн удирдлагын газрын захирал, эдийн засагч, 2008-2011 онд МСиЭс группын Юнител ХХК-ийн газрын захирал, 2011-2020 онд Монголын эдийн засгийн форумын гүйцэтгэх захирал, “Тогтвортой, ногоон санхүүжилтийн хөгжил” холбооны гүйцэтгэх захирал, 2016-2024 онд XYH намын дарга, Удирдах зөвлөлийн гишүүн, 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Байнгын хорооны хуралдааны үеэр нэр дэвшигчээс асуулт асууж, хариулт аваагүй болно.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Бадрахын Найдалааг нэр дэвшүүлснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 94.7 хувийн саналаар дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ**

Л.ЭНХНАСАН